

Ю.Бадамханд

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
Badamkhand.Yu.
Ph. D. colonel, Head of Police Law Department of the Police institute.
Law Enforcement University

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
БАРИМТЛАХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД**

Товч агуулга: Судлаач нь энэхүү өгүүлэлд гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах талаарх олон улсын баримт бичиг, тэр дундаа эрүүгийн болон иргэний хууль тогтоомж дахь хийдэл цоорхой, тэдгээрийг боловсронгуй болгох зорилгоор хууль хэрэгжүүлэх байгууллагад зориулан НҮБ-аас батлан гаргасан загвар хуулийн зохицуулалт, үндэсний хууль тогтоомжид хэрэгжих боломжийн асуудлыг хөндөн авч үзлээ.

Түлхүүр үгс: гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэл, хууль сахиулах байгууллага, цагдаагийн байгууллага, урьдчилан сэргийлэх ажил, стандарт.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах (илааршуулах) асуудал манай улсын шийдвэрлэх чухал асуудлуудын нэг билээ. Ардчилсан зах зээлийн нийгэмд шилжих шилжилтийн он цагийг дагасан нийгэм-эдийн засгийн хүндэрсэн нөхцөл байдлууд нийгмийн нэгж түвшин болох гэр бүл, түүнээс улбаатай бусад институтүүдэд сөргөөр нөлөөлсөн.

Учир нь гэр бүлийн үндэс болох албан ёсны баталгаатай гэр бүлийн тухай ойлголт /стандарт/ өөрчлөгдсөн, амьжиргааны түвшингээс доогуур амьдралтай гэр бүлийн тоо ихэссэн, архидалт, мансуурал зэрэг ужиг үзэгдлүүд газар авсан, нийгмийн зүгээс гэр бүлийн асуудалд оролцох, нөлөө үзүүлэх боломж хязгаарлагдмал болсон.

Зарим гэр бүлд ахуйн хүрээний зөрөлдөөнийг хүч хэрэглэх замаар зохицуулж, улмаар далд нуугдмал байдалд орсон нь онцгой анхаарал татсан асуудлын нэг болж, хувь хүн, нийгэмд хүнд хор уршиг (гэр бүл салж сарнихаас эхлээд гэр бүлийн хэн нэгэн гишүүн бие махбодийн гэмтэл авах, амь нас нь хохирох хүртэл) дагуулах болсон.

1990-ээд оны дунд үеэс дэлхий нийтэд хүний эрхийн ноцтой зөрчил хэмээн хүлээн зөвшөөрөгддөг гэр бүлийн хүчирхийлэл нь манай нийгмийн өмнө тулгарч буй хурцадмал асуудлуудын нэг бөгөөд “Социалист аж төрөх ёс, ариун журамт гэр бүл” хэмээх үзэл суртлын дор халхавчлагдан байсан гэр бүлийн хэн нэгнийгээ хүчирхийлэн дарамтлах үзэгдлийг гэр бүлийн дотоод асуудал бус, хүний эрхийн ноцтой зөрчил хэмээн анх төрийн бус байгууллагаас хөндөн гаргаж ирсэн билээ.

Энэ хугацаанд 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр¹, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон Улсын Дээд шүүхийн тайлбар²,

¹Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр батлах тухай. Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоол.

² Хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэх тухай. Улсын дээд шүүхийн 2006 оны 47 дугаар тогтоол.

заавар, журмуудыг³ батлан хэрэгжүүлж; хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалан байрлуулах байр, гэр бүлд утсаар зөвлөгөө өгөх, эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан⁴ үйлчилгээ үзүүлж ирсэн боловч хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэрэг ноцтой гэмт хэргүүд⁵ гарсаар, энэ талаар гарсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй⁶ байж ирсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгч хариуцлагаас мултрахгүй байх, салбар хоорондын хамтын ажиллагааг нийцүүлэх, иргэд олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хандлагыг өөрчилөх, дагалдах хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулж хууль хоорондын хийдэл, зөрчилдөөнт байдлыг арилгах үүднээс 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэр бүл дэх хүчирхийлэл нь эрүүгийн гэмт хэрэг⁷ болохыг хуульчилж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарч хэрэгжиж эхлээд байна.

Энд гэр бүлийн хүчирхийллээс улбаатай гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээ, шалтгаан нөхцлийг дурьдахыг урьтал болгосонгүй.

Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах арга замын нэг нь хууль сахиулах байгууллагуудын (бүхэлд нь), тэр дундаа энэ төрлийн эрх зүйн зөрчил, нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход голлох үүрэгтэй оролцох цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангахын тулд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны олон улсын стандартуудыг нэвтрүүлэх явдал чухал гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай олон улсын стандартуудын мөн чанарыг нээн харуулсан, түүнчилэн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх салбар дахь судалгаа шинжилгээний ном бүтээлийг судлах нь тэдгээр олон улсын баримт бичигт тусгагдсан, цагдаагийн байгууллагын гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүрэг, үйл ажиллагааны арга хэлбэртэй холбоотой хууль сахиулах практикт хэрэглэгдэх ерөнхий зарчим, чиг баримжаа, заавар зөвлөгөөнүүдийг нарийвчлан таньж мэдэхэд хэрэгтэй.

³ Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр. ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. УБ. 2009; Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2009 оны “Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай” тушаал, Дугаар 308/189/129; Хууль зүйн сайдын 2014 оны гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаарх А/112, А/113, А/114 тоот тушаалууд; Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох заавар; Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлөн эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах заавар. ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. 2009.

⁴ Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам. ЭМ, ХЗДХ, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал. УБ. 2009.

⁵ 2010 оноос хойш сүүлийн зургаан жилд 90 хүн ойр дотны хүмүүсийнхээ гарт амь насаа алдсанаас 2015 онд 24 хүн амь насаа алдсан байна. /ХЭҮТ-ийн судалгаа. 2016.06.19; Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй болон захиргааны зөрчилд тооцогдон арга хэмжээ авагдсан хүчирхийллийн тоо цагдаагийн байгууллагын энэ талаарх тоон судалгаанаас даруй 5 дахин их байгаа. /ХЭҮТ-ийн судалгаа. УБ. 2010.

⁶ Хууль хэрэгжиж эхэлснээс хойших 8 жил гаран хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах 41 шийдвэрийг шүүх гаргасан ч тэдгээр шийдвэрийн нэг нь ч хэрэгжээгүй байна. /Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан. ННФ, ХЭҮТ. УБ.2010.

⁷ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. 11.7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх. //Төрийн мэдээлэл. УБ. 2016. № 7.

Судлан буй сэдвийн хүрээний олон улсын байгууллагуудаас гаргасан эрх зүйн баримт бичгүүд, зөвлөмжүүдэд дүн шинжилгээ хийснээр манай хууль сахиулах байгууллагуудад стандарт болгон баримтлах жишиг дүрэм, түүнд тусгах асуудлуудыг нээн гаргах юм. Үүнд:

Нэгдүгээрт: Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн хувь хүний, тухайн гэр бүлийн асуудал бус, түүний гаралт, урьдчилан сэргийлэх ажилд зохих ёсны анхаарал хандуулах шаардлагатай төрийн үүрэг оролцоо шаардсан, хууль зөрчсөн гэмт хэрэг, хүний эрх, эрх чөлөөний ноцтой зөрчил, хүйсээр ялгаварлах хэлбэр, хүүхдийн эсрэг үл эвлэрэх хүчирхийлэл мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн; хөгжлийн бэрхшээлтэй, нэмэлт асаргаа шаардсан хүмүүсийн хувьд онцгой анхаарсан гэр бүлийн хүчирхийллийн мөн чанарыг тодорхойлох хэм хэмжээнүүд юм.

Хоёрдугаарт: гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн даруйд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг байршуулах хамгаалах байр, үйлчилгээний нэгжүүдийг байгуулах; хүчирхийллийн болзошгүй аюулаас шуурхай хамгаалах; тухайн хэрэг явдлын талаар нотлох баримтад шаардлагатай зүйлсийг цуглуулахдаа гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс оролцож болох хамгийн доод хязгаар /түвшин/-г тодорхойлсон стандарт журмыг баримталсан, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн нэр хүндийг үл басамжилсан хэрэг бүртгэлтийн арга хэлбэрийг боловсруулах; уг хүчирхийлэлтэй гэр бүлд гэр бүлийн, бусад харилцаа бүхий хохирогч, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах; цагдаагийн байгууллагад, тэр дундаа эрүүгийн албанд эмэгтэй алба хаагчдыг ажилд авах асуудлыг сайшаасан; хохирогчийн бие махбодийн болон сэтгэл зүйн байдлыг бүртгэн авч шаардлагатай эрүүл мэндийн болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх; хохирогчийг өс хонзонгийн аливаа үйлдлээс хамгаалах; хүүхдийн эрхийг хангах; эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны өмнө, явцад, дараа нь хохирогчийг хамгаалах; хохирогчийн хэрэгцээг харгалзан гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадвартай шүүхийн, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг бэлтгэн сургах, тэднийг байнга давтан сургах сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах; эрүүл мэндийн, нийгмийн, шүүхийн зэрэг байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагааг зохион байгуулах; хамтарсан үйл ажиллагаанд оролцох төрийн бус байгууллагуудыг сайшаах, дэмжих; хэвлэл мэдээллийн байгууллагын тусламжтайгаар соёлын, соён гэгээрүүлэх, хүмүүжлийн, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа зохион байгуулах, түүнд төрийн бус байгууллагыг татан оролцуулах; тухайн цаг үеийн санхүүгийн боломжоос үл хамааран засаглалын бүх шатанд хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төрийн, тэр дундаа хууль сахиулах байгууллагуудын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүхий л үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээнүүд юм.

Гуравдугаарт: Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх аливаа хүнийг хүйс, арьс өнгө, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө, бусад байдлаар ялгалгүй адил тэгш хамгаалах; төр засгийн зүгээс мэдэж байсан /мэдээлэл авсан/, мэдэж болох байсан эрүүл мэнд, амь насанд нь аюул учирч болох болзошгүй эрсдэлээс хамгаалах бүх боломжит арга хэмжээг авах; гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл илэрсэн тохиолдолд үл хайхарсан байдал гаргаж арга хэмжээ авалгүй өнгөрөөхгүй байх, илрүүлэх, шалтгаан нөхцлийг арилгахад идэвхи гаргах; гэр бүлийн хүчирхийллээс, ялангуяа хохирогчоос гомдол гаргаагүй тохиолдолд хамгаалах арга хэмжээг нэн дауй авах; хууль зүйн болон бусад туслалцаа, зөвлөгөө авах, түүнчилэн тухайн хүчирхийлэл үйлдэгчээс

төлбөрөө барагдуулах, төрөөс зохих тусламж авч болох талаар хохирогчид мэдээлэл өгөх; гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хариуцлагаас мултрахгүй байх боломжийг хангах; төрийн зүгээс болон иргэний нийгмийн байгууллагын тусламжтайгаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх зан үйлийг өөрчилөх ажлыг явуулах зэрэг үйл ажиллагаанд баримтлах ерөнхий стандартууд юм.

Дөрөвдүгээрт: гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үүргийг тодотгосон тусгай стандартууд юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1996 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн тухай загвар хууль”-д⁸ холбогдох гомдол мэдээллийг хүлээн авсан цагдаагийн алба хаагч нь: тухайн гэр бүлд хүчирхийллийн аюул занал байгаа л бол туслалцаа хамгаалалт хүсэн хандсан тохиолдол бүрт хариу үйлдэл үзүүлэх; тухайн гэр бүлийн хэн нэгэн гишүүн гэр бүлдээ хүчирхийлэл үйлдсэн гэсэн хандалт, гомдол мэдээллийг бусад хөндөнгийн хүн зөрчил, гэмт үйлдэл үйлдсэн гэх гомдол мэдээллээс чухал бус гэж авч үзэх эрх байхгүй; гомдол гаргагч хүчирхийллийн аюул занал буй талаар мэдээлсэн, хүчирхийлэл давтан үйлдэгдэх болзошгүй тохиолдолд өөрийн биеэр хэрэг явдлын газарт очих, эргүүл гаргах; гэрч, бусад хүмүүс, хүүхдүүдийг чөлөөтэй ярих боломжийг олгох үүднээс тусдаа өрөөнд оруулж мэдүүлэг авах; дэлгэрэнгүй бичиж авах; хохирогчид зөвлөгөө өгөх, эрхийг нь тайлбарлах; гэр бүлийн хүчирхийллийн талаар тэмдэглэл үйлдэх, түүнийгээ бүртгэлд оруулах; хохирогчийг туслалцаа үзүүлэх, үзлэгт хамруулахаар ойрын эрүүл мэндийн байгууллагад илгээх, хүргэх ажлыг зохион байгуулах; хохирогч, хүүхэд, бусад хамаарал бүхий хүнийг хамгаалах байранд хүргэх; гэрчийг хамгаалах; хамгаалалт шаардлагатай бүх /дам/ хохирогчийг тогтоох; хүчирхийлэл үйлдэгчийг тухайн гэр орноос гаргах /явуулах/, хэрэв боломжгүй хохирогч аюул заналд үргэлжилэн байсаар байхаар бол баривчлах, саатуулах арга хэмжээ авах талаар заасан.

Цагдаагийн алба хаагч нь хохирогчтой түүний ойлгох хэлээр харьцах ба өөрийн нэр, хувийн дугаараа хэлэх үүрэгтэй.

Дээрх хуулиар цагдаа нь хохирогч болон тухайн хүчирхийлэл үйлдэгчид энэ бол гэмт хэрэг гэдгийг хэлэх, тухайн хохирогчийн ойлгох хэл дээр эрх зүйн туслалцааны талаар зааварчилга өгөхийг шаарддаг.

Энэхүү зааварчилсан баримт бичиг нь дараах агуулгыг агуулсан байхыг шаардана: хуулиар хохирогч нь тухайн хүчирхийлэл үйлдэгч /нөхөр, гэрийн эзэн г.м. хэн ч байсан/-ээс түр хамгаалуулах байранд хүргэгдэх эрхтэй; шүүхийн шийдвэрээр өөрийн болон гэр бүлийн өмч хөрөнгөө хамгаалуулах; шүүхийн шийдвэрээр хүчирхийлэл үйлдэгчийг тодорхой хугацаанд гэр орондоо амьдрахгүй байхыг даалгуулах; хэрэв хүчирхийлэл шөнийн цагт, амралтын, баяр ёслолын үеэр үйлдэгдсэн бол шүүхээс эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах; эрх хязгаарлах арга хэмжээ авахуулахад хохирогч нь өмгөөлөгч хөлслөх шаардлагагүй; шүүхийн ажилтнууд эрх хязгаарлуулах арга хэмжээ авахуулахыг хүссэн иргэнд шаардлагатай баримт бичгийн загвар, хуулийн бус туслалцаа үзүүлэх; шүүхэд хандах журам; эрх хязгаарласан арга хэмжээ авсан тухай баримт бичгийг цагдаа гардуулж өгөх ёстой болох зэрэг болно.

⁸ Модельное законодательство о насилии в семье. // http://www.gender.cawater-info.net/publications/pdf/mod_un.pdf

Цагдаагийн алба хаагчийн үүрэгт мөн уг хэргийн үндсэн хэсэг болох илтгэх хуудас бичих орно. Илтгэх хуудасны хувь шүүхийн, бусад шаардлагатай байгууллагад хүргэгдэнэ. Илтгэх хуудасны загварыг цагдаагийн байгууллагын даргаас батална. Түүнд дараах мэдээллийг багтаасан байна: талуудын харилцааны байдал; тэдгээрийн хүйс; ажил эрхлэлт, боловсрол; гомдол мэдээлэл ирүүлсэн огноо, цагдаагийн алба хаагчаас түүнийг хүлээж аваад шалгаж эхэлсэн огноо; хүүхэд хохирсон тухай, тухайн хүчирхийлэл үйлдэгдэх үед хүүхэд байсан эсэх; эрх зүйн зөрчлийн шинж, төрөл; зэвсэг хэрэглэсэн эсэх; хүчирхийлэл үйлдэгдсэн болон цагдаагийн алба хаагчаас арга хэмжээ авсан үеийн огноо; өмнө нь авагдсан эрх хязгаарлах арга хэмжээний эхэлсэн огноо, хүчинтэй байгаа эсэх; гомдол мэдээллийг шалган тогтооход шаардлагатай бусад баримт мэдээллүүд багтана.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон улсын стандартууд нь олон улсын янз бүрийн баримт бичигт хэм хэмжээ, зарчим, зааварчилга хэлбэрээр тусгагдсан байдаг, манай улсын хувьд ч холбогдох хууль, журмууддаа заримыг тусган журамласан байдаг ч дутагдалтай байдал байсаар байгаа билээ.

Энэ талаарх олон улсын эрх зүйн стандартуудын хууль зүйн үндсийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил, хууль сахиулах байгууллагуудын үүрэг оролцоо, зарчим, цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, баримт материал бүрдүүлэх асуудлуудыг тусгасан НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагын эрх зүйн баримт бичгүүд бүрдүүлдэг байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэгдэн байтлагдаж, холбогдох стандарт журмууд боловсрогдон байгаа энэ цаг үед дээрх стандарт шаардлагуудыг тусгах нь зүйн хэрэг билээ.